

Хилийн чанад дахь Монголчуудын үүсгэл санаачилгаар байгуулагдсан, үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга

Нямжавын Номун-Эрдэнэ

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн тэргүүн



1978 онд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төрсөн.

1999 онд МУИС-ийг улс төр судлаач, нийгмийн ухааны багш мэргэжлээр төгссөн. Халх журам хууль зүйн дээд сургуульд багшаар, Боловсролын их сургуулийн дэргэдэх дунд сургуульд цагийн багш

2000-2002 Ундэсний соёл амралтын хурээлэнд дэд захирал, Бишрэлт холдинг ХХК-д хуний нөөцийн ажилтан зэрэг ажлуудыг эрхэлж байсан.

2002-2004 онд хойш Швейцарь улсад ажиллаж амьдарсан.

2004 оноос Швед улсад ажиллаж амьдарч байна.

2009 оноос Швед дэх Монголчуудын Ундэсний Холбоо,

2011 оноос Европ-Монголын нийгэмлэгийн тэргүүний,

2014 оны 1 сараас Цахим Өртөө Холбоо ТББ -ын УЗ-ийн дэд дарга

Гэр бул, 3 хуугийн хамт амьдардаг. Хувиараа аж ахуйн нэгж эрхэлдэг.

Бадралын Мөнхдөл

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга



Б.Мөнхдөл нь Бүтээлч хамтын ажиллагаа чуулга уулзалтын бизнес салбар хуралдааныг зохион байгуулах группт ажилласан бөгөөд одоо ч бизнесийн хөгжлийн хороонд ажиллаж байгаа юм.

Эрэгтэй , 31 настай.

БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ

Бакалавр зэрэг, Бизнесийн Удирдлага 2004 - 2008

Saitama-гийн Их Сургууль, Япон Улс

- Japanese Ministry of Education Scholarship Program (Monbusho)

- Японы Засгийн Газрын Боловсролын дэмжих хөтөлбөр (Monbushu)

Япон хэлний курс 2003 - 2004

Tokyo University of Foreign Studies, Япон улс

Бакалавр зэрэг, Програм Хангамж 2000 - 2002

Компьютер Техник Менежментийн Сургууль

Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

ГАДААД ХЭЛ : Англи, Япон

CoverMongolia ХХК. Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх Захирал 5 сар, 2013 – Одоог хүртэл

Дашцэвэгийн Цэрэнбат

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн тэргүүний зөвлөх



1969 онд төрсөн

Боловсрол

1986 онд Төв аймгийн Алтанбулаг сумын 10 жилийн дунд сургууль,
1991 онд МУИС-ийг математикч мэрэгжлээр төгссөн

2001 онд Английн Kingston University-д MSc in Business and Economic
Forecasting зэрэг хамгаалсан

Ажил

1991-1992 онуудад Улс Төрийн Дээд Сургуульд Дээд математикийн багш

1992-1993 онуудад Төр Нийгмийн Судлалын Академид эрдэм шигжилгээний дэд ажилтан

1993-1997 онуудад Төрийн Захиргаа Удирдлагын Хөгжлийн Институтэд (одоогийн Удирдлагын Академи) Залуур зүйн ухаан, Статистик менежмент, Шийдвэр гаргах тоон аргууд хичээлийг зааж байсан.

2002-одоог хүртэл Английн Custom Networks Ltd компанид санхүүгийн менежерийн ажил хийж буй

Олон нийтийн ажил

1996-97 онуудад Төрийн Захиргаа Удирдлагын Хөгжлийн Институтийг Төгсөгчдийн Холбоог үүсгэн байгуулалцаж тэргүүнээр нь ажиллаж байсан

1999 онд Монгол туургатны Цахим Өртөө сүлжээг санаачилж, үүсгэн байгуулалцсан

1999 онд Британийн Монголчуудын Холбоог үүсгэн байгуулалцаж 2007 оноос тэргүүнээр нь ажиллаж байна

2006 онд Цахим Өртөө Холбоо ТББ-г үүсгэн байгуулалцаж тэргүүнээр нь ажиллаж байна

2005 онд "Монгол орны хөгжилд" жил бүрийн уламжлалт чуулганыг санаачилж, Лондон хотод 8 удаа, Стокхолм хотгоо 1 удаа нийт 9 хамтран зохион байгуулалцсан

2013 оноос сар бүрийн уламжлалт "Оюунлаг Оршихуй" цуврал уулзалтыг санаачилан Элчин Сайдын Яам, Цахим Өртөө Холбоотой хамтран Лондон хотноо зохион байгуулж байна

Жамсранжавын Мөнхжаргал

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Завхан аймгийн Ихуул суманд 1972 онд төрсөн. Улиастай хотын 10 жилийг 1990 онд төгсөөд, УБДС-ийн физик, мэдээлэл зүйн ангид суралцаж байхдаа 2-р курсээс Хятад-Монголын засгийн газар хоорондын оюутны тэтгэлэгт сургалтанд шалгарч Бээжин хотын биеийн тамирийн их сургуулийн ширээний тэннисний дасгалжуулагч багшийн ангийг 1996 онд биеийн тамирийн багш, ширээний тэннисний дасгалжуулагч мэргэжилээр төгссөн. Энэ хугацаандаа Бээжин хотын Олон улсын дунд сургуульд (ОУДС-д) биеийн тамирийн багш, математикийн орлогч багшаар 5 жил ажиллаж байгаад 1999 оноос АНУ-ын Иова мужийн Хойд Иова их сургуулийн урилгаар Эрүүл мэнд, биеийн тамирийн тэнхимд багшлахын зэрэгцээгээр магистерийн зэрэг хамгаалсан.

2001 оноос ХБНГУын Мюнхэн хотын ОУДС болон Jan-Amos-Comenius сургуулиудад биеийн тамирийн болон Хятад хэлний багш, Munich Business School- д Хятад хэлний багшаар тус тус өнөөг хүртэл ажиллаж, амьдарч байна. Гэр бүл 3 хүүхэдтэй.

2007 оноос Мюнхэн хотын "Од " монгол сургуулийг нээж ажиллуулж байна.

Халтархүүгийн Бямбажав

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



1984 онд Завхан аймгийн Яруу суманд малчны гэр бүлд төрсөн.
1993-2000 онд Завхан аймгийн ЭО Нэрэмжит “ЧЭ Цогцолбор” сургуульд сурсан ба 2000-2002 МУИС-ийн лицей, 2006 онд МУИС-ийг Математик, компьютер загварчлал мэргэжлээр төгссөн.

- 2006-2007 онд “Bran Brand” viva студид зураглаач, Эвлүүлэгч, компьютер графикч
- 2008-2009 онд БНТУ-ын Истанбул хотод ‘BRAVO’ сэтгүүлийн газар компьютер графикч
- 2009-2010 онд БНТУ-ын Истанбул хотод ‘FPA’ хэмээх тус улсын Ерөнхийлөгчийн хэвлэл, мэдээлэлийн албанд зураглаач,
- 2010-2011 онд БНТУ-д Истанбул хотод “Best Brothers” ба “TVNET” TV-д зураглаач, эвлүүлэгч, компьютер графикч
- 2011-2013 онд БНТУ-д Истанбул хотод “Best Brothers” ба “TVNET” TV-д дүрсний найруулагч

-2013 оноос эхлэн БНТУ-ын үүрэн телефоны анхдагч оператор “TURKCELL” компанийн урдирдах зөвлөлд зураглаачаар ажиллаж байна.

Дээрх ажлыг хийхийн зэрэгцээ монголчуудынхаа тусын тулд хэвлэл, мэдээллийн салбарт орон зайгаа ажиллаж эхэлсэн болно. Сүүлийн жилүүдэд Монгол, Түрк хоёр орны хамтын

ажиллагаа эрчимтэй өргөжиж, монголчууд Түрк улсад ажиллаж амьдрах, аялах, сурах сонирхол нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар Түрк улсад албан бус тоогоор нийт 3000 гаруй Монгол иргэд ажиллаж, амьдарч, сурч байна. Тэдэнд хоёр орны хөгжил, улс төр, нийгэм соёлын цаг үе, үйл явдлын болон өдөр тутмын мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 2012 оны 11 сараас эхлэн Түрк дэх монголчуудад зориулсан “МОНГОЛ” нэртэй 8-12 нүүр бүхий сонинг төрлөх хэлээрээ эрхлэн гаргаж 15 дугаараа уншигчдынхаа гарт хүргээд байна. Өнгөрсөн сонин Түрк дэх монголчуудынхаа дуу хоолойг “Чөлөөт микрофон” булангаар, Истанбул хот төдийгүй Европын орнуудад амьдарч буй монголчуудын ажил амьдрал, нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хүний мөн чанар гэх мэт зайлшгүй хөндөгдөх сэдвээр чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх боломжийг “Хөндөх сэдэв” буланг ажиллуулж байна. Эх нутаг, орон гэрээсээ хол суугаа монголчууддаа сэтгэлийн дэм, амьдрах итгэл найдвар өгөх, төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлогыг шуурхай хүргэх зорилгыг гол бол болгож ирлээ. Мөн Түрк улсад ирээд удаагүй, хэлний бэлтгэл, күрсэд суух боломжгүй оюутан залуус, иргэдэд зориулан анхан шатны түрк хэлний мэдлэг олгохоор “Түрк хэлний хичээл” гэх мэт монголчуудынхаа хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах сонины булангууд маань улам баяжиж нэмэгдсээр байна.

Улмаар сонин гарган мэдээлэл хүргэх хүрээгээ тэлэн Түрк улсад төдийгүй дэлхийн бусад улс оронд ажиллаж амьдарч, сурч байгаа нийт монголчууддаа цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай, үнэн бодитой, хүртээмжтэй хүргэх зорилгоор Түрк болон Европын улс орнуудад анхдагч “Ай Монгол” интернет радиог үүсгэн байгуулж, Истанбул хотоос шууд эфирээ цацаж эхлээд жил гаран боллоо.

Бид Түрк улсын Истанбул хотод ажиллаж амьдарч байгаа монголчуудын 10-13% болох 1,5-6 насны нийт 147 хүүхэдийн, 64,6% буюу 95 хүүхэдийг сургуулийн өмнөх боловсрол олгох тулд бага, дунд, ахлах гэсэн 3-н анги гаргахаар төлөвлөв. 2014 оны 10 сарын 13-нд эхний анги болох 20 хүүхэдтэй дунд, ахлах гэсэн 2 ангийг нээн ажилуулаад байна.

Пэрэнлэйн Эрхэмбаяр

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



1987 онд Говь-Алтай аймгийн Алтай хотод төрсөн.

2005 онд Математик Физикийн гүнзгийрүүлсэн сургалттай 5р сургуулийг төгсөж, Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд элсэн орсон.

2006 оны зун Америкийн нэгдсэн улсад суралцахаар ирсэн бөгөөд 2011 онд Миннесота мужийн Saint Cloud State University-г санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр амжилттайтөгссөн.

Одоо Чикаго хотод амьдарч Chartered Financial Analyst (CFA) зэрэг авахаар суралцажбайгаагаас гадна үргэлжлүүлэн Бизнесийн Удирдлагын магистарт сурах гэж байгааболно.

2014 оны 8 сараас Чикаго хотын Америк-Монголын Холбооны (American Mongolian Association)гүйцэтгэх захирал

Ира

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Төрсөн он: 1977

Оршин суугаа газар: 2003 оноос хойш Өмнөд Солонгос Гёнги муж Соннам хот

Гэр бүлийн байдал: Нөхөр 2 хүүхдийн хамт

Боловсрол: Солонгосын Шингү их сургуулийн visual design, Каннам их сургуулийн нийгмийн ажилтны анги төгссөн. Одоо Ёнсэй их сургуульд төрийн удирдлагаар мастерт сурч байгаа.

Ажлын байдал: 2000-2002он хүртэл 3, 4-р цахилгаан станцын тоног төхөөрөмж шинчлэлийн төслийн гүйцэтгэлийн албанд менежер орчуулагч,

2008-2010он хүртэл солонгосын English Forum компанид цахим сургалатын дизайнер.

2010-2014 он Солонгосын Гёнги мужийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүн.

Нийгмийн ажлын байдал: 2007оноос 2010он хүртэл Сөүл хотын цагаачлалын албаны дэргэдэх цагаач эмэгтэйчүүдийн нийгэмлэгт монгол төлөөлөгч, дэд дарга.

2010 онд солонгос дах монгол эмэгтэйчүүдийн холбоог санаачлан зохион байгуулж зөвлөхөөр ажиллаж байсан.

2011 оноос солонгосд оршин сууж байгаа гадаад эмэгтэйчүүдийн сайн дурын нийгэмлэгийг санаачлан удирдан ажиллаж байгаа.

2013онд солонгос дах монгол иргэдийн холбоог санаачлан 2014онд албан ёсоор байгуулж холбооны даргаар ажиллаж байна.

2014оноос солонгосчуудад зориулсан солонгост амьдарч байгаа гадаад иргэдийн тухай болон олон улсын соёлын тухай цахим радио багт хамтран ажиллаж байгаа

Хатантөмөрийн Оюунгэрэл

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Боловсрол: Москва хотын дээд сургууль, Монгол улсын Гадаад харилцааны дээд сургууль

Ажил, мэргэжил : Ноосон эдлэлийн говь комбинат, Худалдаа үйлдвэрийн яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад 2001 онд АНУ-д ажиллаж амьдарч байна. Монгол Америк эмэгтэйчүүдийн Холбоог 2009 эхлэн үүсгэн зохион байгуулж тэргүүнээр нь одоог хүртэл ажиллаж байна.

Дэчинбэгзийн Амараа

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Монгол хэл уран зохиолын багш, 2000 онд УБ дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр, 2003 онд магистр тус тус төгссөн.

2004 оноос 2010 он хүртэл Германы "Arber" компанид ажиллаж байгаад 2010 оноос одоог хүртэл Бельги улсад ажиллаж амьдарч байна.

1996,2000 оны УИХ-ын сонгуулийн ажлыг Хөтөлд зохион байгуулсан, сонгуулийн хорооны даргаар ажиллаж байсан.

1994-1999 он хүртэл Хөтлийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргаар ажиллаж байсан. 14 жил дунд сургуульд багшилсан. 2012 оноос Бельги дэхь эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга..2014 оны 6 сараас Ёврод дахь

Монголын Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүнээр ажиллаж байна.

Чулуунбатын Энхбат

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Төрсөн газар, огноо: Улаанбаатар хот, 1978 он

1986 - 1988 Улаанбаатар хотын 31-р дунд сургууль

1988 - 1996 ОХУ, Пермь хотын Балетын Колледж

1996 - 1999 Унгар Улс, Будапешт хот, Хувийн компаний захирал

1999 - 2000 Унгар Улс, Будапешт хот, Баллаши Институт унгар хэлний бэлтгэл

2000 - 2006 Унгар Улс, Будапешт хот, Эөтвөш Лорандын нэрэмжит Эрдэмийн Их Сургууль Эрх Зүй, Улс төр судлалын Факултет. Эрх Зүйч, Улс төрийн судлал (дэд докторын зэрэг)

2001 - 2002 Унгар Улс, Будапешт хот, Эөтвөш Лорандын Нэрэмжит Эрдэмийн Их Сургууль. Монгол-Унгар албан ёсны орчуулагч, хэлмэрч

2006 - Өмгөөлөлч

2003 - 2006 Унгар дахь Монголчуудын Холбоо, Удирдах Зөвлөлийн гишүүн

2006 - 2011 Унгар дахь Монголчуудын Холбоо, Гүйцэтгэх захирал

2011 - Унгар дахь Монголчуудын Холбоо, Ерөнхийлөгч

Б. Булганмаа

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн



Бүүвэйбаатарын Булганмаа нь Австрали улсад ажиллаж амьдардаг. Сүүлийн 17 жил мэдээллийн технологи, харилцаа холбоо болон Австрали улс дахь Монголчуудын холбоо, оюутны Холбоонд идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн. / Gegeen Australia гэдэг нэрээр танигдсан/

Товч намтар:

2005 оноос одоог хүртэл -

Гэгээн Ундрага Холбоо ТББ / Үүсгэн байгуулагч, тэргүүн / 2010 онд Монголыг шилдэг блогод шалгарч байсан www.gegeen.com

2007 оноос одоог хүртэл -

Австрали дахь Монгол Оюутны холбооны тэргүүн

2010 оноос

Blue Water Accommodation & Study Service Pty Ltd, Sydney

Суралцах, ажиллахад Зөвлөгөө өгөх, жуучлах агентур

Боловсролын байдал:

1997 онд Математик, Физикын сургалттай 11 -р сургууль

2001 Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

Bachelor of Computer Science in SW Engineering

2001 Боловсролын их сургууль

2002 Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль

Master of Computer Science in SW Engineering

2002 National Information Centre of India, New Delhi / Microsoft Certified System Engineer

2003 Okinawa International Center of Japan, Okinawa

Database Engineer, plus Japanese language certificates

2005 Griffith University of Brisbane, Australia

/ Master of Information and Communication Technology

2005 DataAspects Pty. Ltd, Gold Coast, Australia / MCSD, MCDBA, MCSE, MCSA training

2009 KIC, Seoul, South Korea / International IT Conference participant

2014 WEBA World, Los Angeles, California, USA / Education Agencies Trainee

Мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр ажиллаж байсан газрууд:

Australia : UBMMedicaPtyLtd, AJSComputingServicesPtyLtd, UtilInc. – Sydneybranch, CupidMediaPtyLtd,GoldCoast, SilvershotzPtyLtd,

Mongolia : Ministry of Nature, Environment and Tourism, Mongolian University of Science & Technology (Computer Science and Management School), Asian Development Bank and Mongol Bank / Project team member and Translator, ABMA hospital, Mongolia Today News Agency & Blue Mongolia Travel Agency

Жанчивын Өнөрмаа

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Урлаг соёлын менежмент, аялал жуучлалын хорооны дарга



Европ-Монголын Нийгэмлэгийн Дэд тэргүүн,
Британийн Монголчуудын Холбооны УЗ-ийн гишүүн,
Цахим Өртөө холбооны гишүүн

Ж. Өнөрмаа нь Лондон хотод амьдардаг. Орчуулга, консалтинг, урлагийн менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өөрийн компанийг 2007 онд байгуулахаасаа өмнө Британийн Засгийн

газарт үйлчилгээ үзүүлдэг орчуулгын компанид Бичгийн болон шүүхийн орчуулгын хэлтсийн даргаар таван жил ажилласан. Монголд УИХ-ын Гадаад харилцааны хэлтэс болон Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн төвд олон улсын харилцааны мэргэжилтнээр ажиллаж байсан өндөр туршлагатай; Хэл шинжлэлийн ухааны бакалавр (1991), Бизнесийн удирдлагын магистрын курс (2007-2009), мөн Уэстминстерийн Их сургуулийг Дипломат судлал, олон улсын харилцааны магистр (2001) цолтой төгсөхдөө “Европын Холбоо ба Ази: Европын Холбоо, Монгол Улсын харилцааны хэтийн төлөв” сэдвээр зэрэг хамгаалсан. Ж. Өнөрмаа нь Монголын урлаг, соёл Лондонд" ашгийн бус төрийн бус байгууллагынхаа шугамаар “Монгол” брэнд, Монгол соёлын өвийг Британи болон Европын бусад орнуудад байнга сурталчилдаг:

<http://mongolianartlondon.wordpress.com>.

Мөн Монголд хөрөнгө оруулагчдад зөвлөлгөө өгч, хамтран ажилладаг.

Самбуугийн Болор

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Бизнесийн хөгжлийн хорооны дарга



Канад-Монголын худалдааны танхимын гүйцэтгэх захирал

Болор нь аливааг бие даан санаачлан нийгмийн салбарт бизнес эхлүүлж цааш нь үр дүнтэй хөгжүүлэгч залуу нэгэн. Тэрээр нийгмийн олон төрлийн бүлгүүдтэй ажиллах сонирхолтой бөгөөд олон талаас нь тунгаан шийдвэр гаргах орчинд илүү сайн амжилттай ажилладаг. Тус танхимд гүйцэтгэх захиралаар ажиллахын зэрэгцээ Болор нь Монголын уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилготой Монголын уул, уурхай дахь эмэгтэйчүүд нэртэй төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан.

Урьд нь Монголын төрийн мэдлийн Эрдэнэс Таван Толгой компанид гадаадын санхүүгийн зах зээл дээр хувьцаа гаргаж, хөрөнгө босгох

асуудлыг хариуцан ажиллаж байв. Канадад байх хугацаандаа Болор Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэгэн канадын компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй коксжих нүүрсний орд газар эзэмшдэг Монголын компаныг худалдан авах асуудлаар зөвлөгөө өгсөн. Канадын Үнэт цаасны биржид санхүүгийн шинжээчээр ажиллаж эхэлсэн үеэс санхүүгийн болоод уул уурхайн хөрөнгө оруулалтын салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Мөн АНУ-ын Чикаго хотод байрлах H&R Block санхүүгийн компанид татварын асуудал хариуцсан зөвлөгчөөр ажиллаж байсан.

Болор Канадын Викторийн их сургуульд Бизнесийн удирдлагын магистр, Польшийн Варшавийн Их сургуульд Олон улсын эдийн засгийн чиглэлээр Магистр, Бакалаврийн зэрэг хамгаалсан. Англи, Польш, Орос хэлтэй.

Өлзийн Оюунтүлхүүр

*ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн*Боловсролын хорооны дарга



1970 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд төрсөн.

Боловсрол

1987 онд УБ хотын 13 р дунд сургуулийг

1992 онд УБИС -ын монгол хэл уран зохиолын ангийг

1995 онд Удирдлагын хөгжлийн академийг төрийн албаны зохион байгуулагч ,менежер мэргэжлээр тус тус төгссөн.

Хэл шинжлэлийн ухааны магистер.

Ажил

1992-1994 онуудад "Орхон"гадаад хэлний дээд сургуульд багш

1995-2000,мөн 2005 онуудад UBS -TV д сурвалжлагч,сэтгүүлч,мэдээллийн албаны дарга зэрэг ажлуудыг хийж байсан.

2000 оноос Герман улсын Штуттгарт хотод амьдарч ажиллаж байна.

Монголчууддаа зориулсан "Энх-удам " Европын аялал жуулчлалын компанийг ажиллуулдаг.

2009 оноос "Солонго"монгол хэлний сургуульд багшилж байна.

Штуттгарт хотын Монгол академичдын холбооны гишүүн.

Батсайханы Энхгэрэл

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Оюутан Залуучуудын хорооны дарга



Төрсөн он, газар: Улаанбаатар хот 1990 он

Төгссөн сургууль: “Хишиг” хятад хэлний дунд сургууль,
Хүмүүнлэгийн Ухааны их сургууль

Одоо : Тайваний Chinese Culture Univesrity-д Олон Улсын Бизнес
Удирдлагаар мастер хамгаалахаар суралцаж байгаа

Англи , Хятад хэлтэй

- 2014 он Тайвань дахь Оюутан Залуучуудын холбоо тэргүүн
Монгол Тайвань Бизнес Эрхлэгчдийн хөгжлийн сан үүсгэн байгуулагч, тэргүүн
- 2013 он “Frontier Securities” хяналтын мэргэжилтэн
- 2012 он “ Grand Mining ” Ерөнхий захирал хувийн туслах, менежер
- 2011 он “СТС” гадаад худалдаа хариуцсан менежер

Бэлэгбадрахын Энхтүвшин

ТББ-уудын нэгдсэн зөвлөлийн Мэдээлэл харилцааны албаны дарга



Төрсөн он 1976

Амьдардаг улс :ХБНГУ

Сургууль /ажил

Хөвсгөл аймаг, Мөрөн хот. Математик Байгалийн ухааны дунд сургууль

ТИС КТМС – Программ хангамжийн инженер

ХБНГУ – Берлин хотын Техникийн их Сургууль - Программ хангамж

БСБ Сервис, Адмон ХХК, Finalsoft GmbH байгууллагуудад ажиллаж
байсан

Одоо эрхэлж буй ажил : The German Insurance Association

Монгол-Германы эдийн засгийн клубын удирдах зөвлөлийн гишүүн

Цог спорт клубын удирдах зөвлөлийн гишүүн

„Монголчууд Германд“ Мэдээллийн Портал сайтын ерөнхий зохицуулагч